



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2022 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/50

Алтай хот

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2, 19.18, дахь хэсэг, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн чиглэлээр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох комиссын 2022 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг шинээр олгох, хугацааг сунгах байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 2012 оны
01 дугаар сарын 17-ны өдрийн 159 дугаар
захирамжийн хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ СУНГАХ БАЙГУУЛЛАГЫН
НЭР, ХУГАЦАА

№	Аж ахуйн нэгжийн нэр	Байгууллагын нэр	Үйл ажиллагааны чиглэл	Тусгай зөвшөөрлийг сунгах хугацаа	Тусгай зөвшөөрлийг шинээр олгох
1	"Зайвар-Алтай" ХХК	"Энхмөнх дэлгэрэх"	Халдвартын клиник	5	
2	Тонхил сум	"Тунгалаг фарм"	Эмийн сан		3
3	Дарив сум	"Хотойн хандмал"	Эмийн сан		3
4	"Хансан панзат" ХХК	"Сэтгэлийн гэгээ"	Клиник эмнэлэг		3
5	АШУҮИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны сургууль	"Эмнэлзүйн алба"	амбулатори, лаборатори клиникт		3